

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020.04.20

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2020.4.20 ны өдрийн 14 цагт эхэлж, 15цаг хүртэл 1 цаг Компанийн хурлын танхимд болов.

Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдсон хурлын дарга Лхагва овогтой Янжин нээж үг хэлэв.

Хурлын дарга Л.Янжин: Дэлхий дахинд тараад буй Ковид-19 хар тахлаас үүдэн олон хүнийг нэг дор цуглуулах, хурал цуглаан зохион байгуулахыг хориглосон, иймээс онлайнаар энэ удаагийн хурлыг зохион байгуулж байгаараа их онцлог байна. Мөн манай компани 2020.04.06 ны өдрөөс эхлэн компани дээрээ хурлын материалыг танилцуулан саналыг авсан болно. Хувьцаа эзэмшигч та бүгдийг "Талх Чихэр" ХК-ийн пэйж хуудсанд хандан хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна гэв.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2020.04.20 ний өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Г.Энх-Оюун уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Г.Энх-Оюун : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд ширхэг хувьцаа эзэмшсэн 1.023.703 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 734126 ширхэг хувьцаа эзэмшсэн 165 хувьцаа эзэмшигч бүртгүүлж саналаа өгсөн байна. Энэ нь нийт хувьцааны 71,7 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа хурал даргалагч байраа эзлээд хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2020 оны зорилт, бизнесийн төлөвлөгөөг батлах
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, 2020 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 225 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :

- 61
1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2020 оны зорилт, төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал М.Базар-Ууган тайлагнав.
 2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг дотоод аудитор С.Дүгэр тайлагнав.

Үүний дараа Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, 2020 оны төсөв, "Ногдол ашиг хуваарилах" тухай тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга Л.Янжин: Хэлэлцэх асуудлын дараа хувьцаа эзэмшигчдээс онлайнаар асуусан асуултанд хариулъя. Асуултанд компанийн ерөнхий менежер С.Тамираа, "Зүүн бүс" төслийн зохицуулагч Б.Тулгаа болон холбогдох хүмүүс хариулна гэв.

Хувьцаа эзэмшигч Ц.Хангарьд: Ковид-19 хар тахлын улмаас 2020 онд борлуулалт буурах, эсвэл өсөх талаар ямар хандлагатай байна вэ? Үйлдвэрлэлд хэрхэн нөлөөж байна вэ?

Б.Тулгаа: Корона вирус дэлхий дахинд дэгдсэн энэ үед манай компанид ч гэсэн нөлөөлж байна, борлуулалт бууралттай байна. Хэдий бууралттай байгаа боловч компанийн зүгээс ажилчдынхаа орон тоог цомотгохгүй, хэвээр хадгалахыг зорьж байна.

Хувьцаа эзэмшигч Д.Одонгэрэл: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэх нөөц хир байна вэ?

С.Тамираа: Короно вирусын үед үйлдвэрлэлийн нөөц түүхий эд, бүтээгдэхүүн одоогоор тасраагүй байна, 3 сарын нөөц байна, гэхдээ гадаад захиалга тасрах магадлалтай байгаа, гадаад орнууд хил гаалиа хаасантай холбоотой.

Хувьцаа эзэмшигч Д.Пүрэвсүрэн: Үйлдвэрлэлийн өргөтгөлийн талаар мэдээлэл өгнө үү?

Б.Тулгаа: Зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх болон олон улсын стандартуудын шаардлагыг хангах явцад хэд хэдэн зайлшгүй шаардлага хэрэгцээ бий болсон.

1. Нийслэл болон хөдөө орон нутгийн хэрэглэгчдэд бараа бүтээгдэхүүнийг шинэлэг байдлаар нь хүргэхэд шаардлагатай хөргөлт, савлагаа

2. Түүхий эдийн агуулах

3. Савлагааны цех

4. Борлуулалтын ачилтын покс зэргийг өргөтгөх зайлшгүй шаардлага бий болсон. Иймээс хөрөнгө оруулагчийг татан түүхий эдийн агуулах, савлагааны цех, борлуулалтын ачилтын покс зэргийг өргөтгөлөө. Мөн бейкериний төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөтгөх ажлыг амжилттай зохион байгууллаа.

02

Хурлын дарга Л.Янжин: Хариултыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, та бүгдийн саналыг хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Г.Энх-Оюун “Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай” тогтоолыг уншиж танилцуулав./ уг тогтоолыг хурлын материалын..... хуудсанд хавсаргав.

Компанийн нийт 1,023,703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3926 хувьцаа эзэмшигчдээс хуралд 734126 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 165 хувьцаа эзэмшигч хуралд орлцов.

Тооллогын комиссоос тараасан саналын хуудас 165 ширхэг, хураан авсан саналын хуудас 165 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын тоо 159 асуулга тус бүрээр хүчингүй саналын тоо 6 байна.

1. Компаний 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 734008 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
2. Компанийн 2020 оны зорилт, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 734008 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь.
3. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийг 51.150.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 734008 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналынхувь
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 225 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 734008 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь, түдгэлзсэн ширхэг хувьцаа буюу нийт саналын хувь байна

Иймд дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулсугай гэж танилцууллаа.

Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлаас №01 тоот тогтоол гаргав.Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2020 оны зорилт, бизнесийн төлөвлөгөөг баталсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг 51.150.000 төгрөгөөр баталсугай.
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 225 төгрөгөөр тогтоосугай

63


гэж Тогтоолыг уншиж танилцуулсанаар хурлын үйл ажиллагаа өндөрлөв. Хурлыг хааж хурлын дарга Л.Янжин: Хуралд идэвхитэй оролцсон хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа гэв.

Хурлын дарга



Л.Янжин

Тэмдэглэсэн



И.Өлзийбаяр

